



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар Б/251

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Өлзийт санал Өрхийн эрүүл мэндийн төвийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухайн хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 6,990,000.0 /Зургаан сая есөн зуун ерэн мянган/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хороо Өлзийт манал Өрхийн эрүүл мэндийн төв /Л.Тогоо/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хороо Өлзийт манал Өрхийн эрүүл мэндийн төв /Л.Тогоо/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 07 сарын
 10 өдрийн А/251 дугаар тушаалын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хороо, Өлзийт манал ӨЗМТӨв

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Хаш чулуун ор	SER-AGEM V13	12 үйлдэлтэй	2017	Ш	1	6,990,000	6,990,000	Мөнх Тогтвортой хөгжил сан ТББ	Хандив
Тавилга эд хогшлын дүн						1		6,990,000		
Нийт зөвшөөрөл авах хөрөнгийн дүн						1		6,990,000		